



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/54/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)  
Архангай аймаг  
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Аудитор Л.Соёлмөнх  
Утас: 7033-3019

Цахим хаяг: [Soyolmunkhl@audit.gov.mn](mailto:Soyolmunkhl@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.20 № 25

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН  
ЦАХИР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Х.ОТГОН-ЭРДЭНЭ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшуулал 4,041.3 мянган төгрөгийг илүү олгосон.
2. Хурлын төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардалд анхан шатны баримтын бүрдэл дутуу 14,490.0 мянган төгрөгийг зарцуулсан.
3. Цалингийн сангаас улс төрийн албан хаагчид 2,808.0 мянган төгрөгийн урамшууллыг олгож, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн.
4. Тэтгэмж урамшууллын зардлыг 950.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын

2.3 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа хөтөлбөрийн үйл ажиллагааны зардал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг гэсэн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 191,037,1 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 181,186.7 мянган төгрөгийг зарцуулж, 10,800.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан 21 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 80-90 хувийн гүйцэтгэлтэй 8 арга хэмжээ, 70 хувийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 94.2 хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>I</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>310,500.00</b>	<b>264,000.00</b>
<b>35.00</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>310,500.00</b>	<b>264,000.00</b>
354.00	Хангамжийн материал	310,500.00	264,000.00
3,541.00	Бичиг хэргийн материал	48,000.00	101,500.00
3,542.00	Аж ахуйн материал	262,500.00	162,500.00
<b>II</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,486,466.33</b>	<b>56,780,056.83</b>
<b>39.00</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,486,466.33</b>	<b>56,780,056.83</b>
<b>392.00</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,278,132.96</b>	<b>56,671,723.42</b>
39,203.00	Авто-тээврийн хэрэгсэл	-	60,000,000.00
39,204.00	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,000,000.00)
39,205.00	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,855,000.00	10,985,000.00
39,206.00	Хуримтлагдсан элэгдэл	(8,619,216.96)	(8,532,416.59)
39,207.00	Тавилга, аж ахуйн эд хогшил	638,840.00	258,840.00
39,208.00	Хуримтлагдсан элэгдэл	(596,490.08)	(39,699.99)
393.00	Биет бус хөрөнгө	208,333.37	108,333.41
39,301.00	Програм хангамж	300,000.00	300,000.00
39,302.00	Хуримтлагдсан элэгдэл	(91,666.63)	(191,666.59)
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,796,966.33</b>	<b>57,044,056.83</b>
<b>IV</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>133,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>133,000.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>-</b>	<b>133,000.00</b>
<b>4132</b>	<b>Бараа үйлчилгээний зардлын өглөг</b>	<b>-</b>	<b>133,000.00</b>
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,796,966.33</b>	<b>56,911,056.83</b>
<b>51.00</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,796,966.33</b>	<b>56,911,056.83</b>
511.00	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	679,000.00	679,000.00
51,101.00	Өмч: - төрийн	679,000.00	679,000.00
512.00	Хуримтлагдсан үр дүн	5,093,089.03	56,207,179.53
5,121.00	Өмнөх үеийн үр дүн	5,093,089.03	5,093,089.03
5,122.00	Тайлант үеийн үр дүн	-	51,114,090.50
513.00	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,877.30	24,877.30
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,796,966.33</b>	<b>57,044,056.83</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>105,846,000.00</b>	<b>252,547,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>400,000.00</b>	<b>60,560,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>400,000.00</b>	<b>60,560,000.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	300,000.00	60,560,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	100,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>105,446,000.00</b>	<b>191,987,100.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>105,446,000.00</b>	<b>191,987,100.00</b>

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,446,000.00	191,987,100.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>109,891,813.81</b>	<b>201,202,176.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>109,891,813.81</b>	<b>201,202,176.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>107,048,126.15</b>	<b>179,569,744.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>78,082,801.46</b>	<b>118,537,924.84</b>
210101	Үндсэн цалин	54,144,781.28	76,789,159.44
210102	Нэмэгдэл	17,306,320.66	33,495,891.40
210104	Урамшуулал	6,631,699.52	8,252,874.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,013,410.88</b>	<b>14,753,279.27</b>
210201	Тэтгэврийн даатгал	4,893,010.88	10,158,933.68
210202	Тэтгэмжийн даатгал	780,100.00	1,114,138.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	636,069.29	843,144.03
210204	Ажилгүйдлийн даатгал	144,030.71	266,135.43
210205	Эрүүл мэндийн даатгал	1,560,200.00	2,370,928.08
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,825,000.00</b>	<b>17,094,170.00</b>
210401	Бичиг хэрэг	1,840,000.00	4,964,310.00
210402	Тээвэр, шатахуун	5,800,000.00	11,935,360.00
210404	Ном, хэвлэл	185,000.00	194,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>918,000.00</b>	<b>3,836,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	918,000.00	3,836,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,918,700.00</b>	<b>607,294.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,918,700.00	582,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	17,544.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	6,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,290,213.81</b>	<b>24,741,076.31</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	468,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	844,400.00	15,705,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,977,813.81	9,035,576.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,843,687.66</b>	<b>21,632,431.89</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	10,832,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	9,582,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,843,687.66	10,800,431.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,843,687.66	10,800,431.89
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(4,045,813.81)</b>	<b>51,477,923.69</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>230,833.19</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	230,833.19
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(230,833.19)</b>
<b>V</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(4,045,813.81)</b>	<b>51,114,090.50</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>105,446,000.00</b>	<b>191,987,100.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>105,446,000.00</b>	<b>191,987,100.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>105,446,000.00</b>	<b>191,987,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,446,000.00	191,987,100.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>105,446,000.00</b>	<b>191,987,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>105,446,000.00</b>	<b>191,987,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>102,602,312.34</b>	<b>170,354,668.11</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>76,344,912.34</b>	<b>118,537,924.84</b>
210101	Үндсэн цалин	53,008,746.03	73,777,859.44
210102	Нэмэгдэл	16,704,466.79	36,507,191.40
210104	Урамшуулал	6,631,699.52	8,252,874.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>9,751,300.00</b>	<b>14,753,279.27</b>
210201	Тэтгэврийн даатгал	6,630,900.00	10,158,933.68
210202	Тэтгэмжийн даатгал	780,100.00	1,114,138.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	636,069.29	843,144.03
210204	Ажилгүйдлийн даатгал	144,030.71	266,135.43
210205	Эрүүл мэндийн даатгал	1,560,200.00	2,370,928.08
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,825,000.00</b>	<b>15,630,620.00</b>
210401	Бичиг хэрэг	1,840,000.00	4,918,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,800,000.00	10,518,310.00
210404	Ном, хэвлэл	185,000.00	194,310.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>918,000.00</b>	<b>3,703,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	918,000.00	3,703,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,918,700.00</b>	<b>2,024,344.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,918,700.00	2,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		17,544.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		6,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>844,400.00</b>	<b>15,705,500.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	844,400.00	15,705,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,843,687.66</b>	<b>21,632,431.89</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000,000.00</b>	<b>10,832,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		9,582,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,843,687.66	10,800,431.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,843,687.66	10,800,431.89
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	-	-
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	9,138,902.84	9,842,780.14
7	Тайлант үеийн үр дүн			(4,045,813.81)	(4,045,813.81)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	5,093,089.03	5,796,966.33
17	Тайлант үеийн үр дүн			51,114,090.50	51,114,090.50
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	679,000.00	24,877.30	56,207,179.53	57,911,056.83

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>191,037,100.00</b>	<b>181,186,668.11</b>	<b>9,850,431.89</b>	<b>94.84</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>191,037,100.00</b>	<b>181,186,668.11</b>	<b>9,850,431.89</b>	<b>94.84</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>181,155,100.00</b>	<b>170,354,668.11</b>	<b>10,800,431.89</b>	<b>94.04</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>127,633,600.00</b>	<b>118,537,924.84</b>	<b>9,095,675.16</b>	<b>92.87</b>
210101	Үндсэн цалин	127,633,600.00	73,777,859.44	53,855,740.56	57.80
210102	Нэмэгдэл	-	36,507,191.40	(36,507,191.40)	-
210104	Урамшуулал	-	8,252,874.00	(8,252,874.00)	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,954,200.00</b>	<b>14,753,279.27</b>	<b>1,200,920.73</b>	<b>92.47</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,848,800.00	10,158,933.68	689,866.32	93.64
210202	Тэтгэмжийн даатгал	1,276,300.00	1,114,138.05	162,161.95	87.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,021,100.00	843,144.03	177,955.97	82.57
210204	Ажилгүйдлийн даатгал	255,300.00	266,135.43	(10,835.43)	104.24
210205	Эрүүл мэндийн даатгал	2,552,700.00	2,370,928.08	181,771.92	92.88
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,821,600.00</b>	<b>15,630,620.00</b>	<b>190,980.00</b>	<b>98.79</b>
210401	Бичиг хэрэг	4,920,000.00	4,918,000.00	2,000.00	99.96
210402	Тээвэр, шатахуун	10,661,600.00	10,518,310.00	143,290.00	98.66
210404	Ном, хэвлэл	240,000.00	194,310.00	45,690.00	80.96
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,832,000.00</b>	<b>3,703,000.00</b>	<b>129,000.00</b>	<b>96.63</b>
210702	Дотоод албан томилолт	3,832,000.00	3,703,000.00	129,000.00	96.63
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,163,700.00</b>	<b>2,024,344.00</b>	<b>139,356.00</b>	<b>93.56</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	93,700.00	-	93,700.00	

210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	17,544.00	42,456.00	29.24
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	10,000.00	6,800.00	3,200.00	68.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,750,000.00</b>	<b>15,705,500.00</b>	<b>44,500.00</b>	<b>99.72</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,750,000.00	15,705,500.00	44,500.00	99.72
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,882,000.00</b>	<b>10,832,000.00</b>	<b>(950,000.00)</b>	<b>109.61</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,882,000.00</b>	<b>10,832,000.00</b>	<b>(950,000.00)</b>	<b>109.61</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,582,000.00	9,582,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	1,250,000.00	(950,000.00)	416.67
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>191,037,100.00</b>	<b>181,186,668.11</b>	<b>9,850,431.89</b>	<b>94.84</b>
<b>132</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>191,037,100.00</b>	<b>181,186,668.11</b>	<b>9,850,431.89</b>	<b>94.84</b>
132001	Орон нутгийн төсвөөс	191,037,100.00	181,186,668.11	9,850,431.89	94.84
<b>2</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>5</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>6</b>	<b>Удирдах ажилтан</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>100.00</b>
<b>7</b>	<b>Гүйцэтгэх ажилтан</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.00</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **133.0** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 133.0 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- ✓ Албан томилолтын зардалд 133.0 мянган төгрөгийг нэг албан хаагчид дутуу олгосон бөгөөд санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй орхигдуулсан нь УСНББОУС 1, 19, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.4.1, 13.1 дэх заалт болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул бараа материалын тайланд залруулга хийлгэлээ.

Мөн аудитаар нийт **22,289.3** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд зөрчил таслан зогсоож, арилгуулах 4 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 22,289.3 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **2,149.2** мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр захирамжаар сумын ИТХ-ын нарийн бичгийн даргад хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллыг сүүлийн сарын үндсэн цалинг 6 дахин нэмэгдүүлж тооцон 3,348.7 мянга, хувь хүний орлогын албан татварт 692.6 мянган төгрөг суутгаагүй нийт 4,041.3 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3-т "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-т "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 18/06 дугаар тогтоолоор хурлын даргад 2,808.0 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас олгож, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Мөнгөн урамшууллыг цалингийн сангаас олгосон зөрчлийг таслан зогсоож, зориулалтын дагуу зарцуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүллээ.

5.2.2 Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 13 дугаар захирамжаар хурлын төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах үйл ажиллагааны зардалд анхан шатны баримтын бүрдэл дутуу 14,490.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн мөрдөж, Төлөөлөгчдийн тойрогт ажилласан үйл ажиллагааны зардлын анхан шатны баримтын бүрдлийг ханган хянуулах албан шаардлага хүргүүллээ.

5.2.3 Тайлант онд байгууллагын нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын батлагдсан төсвийг хэтрүүлэн 950.0 мянган төгрөгийг албан хаагчдын тэтгэмж урамшуулалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан томилолтын 133.0 мянган төгрөгийн өглөгийг бүртгэл тайланд тусгаагүй	1	133.0	1	133.0	-	-	1	133.0	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөдөө орон нутгийн нэмэгдэл илүү олгосон.	1	4,041.3	1	4,041.3	-	-	-	-				
Хурлын даргад цалингийн сангаас урамшуулал олгосон	1	2,808.0			1	2,808.0	-	-				
Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	14,490.0			1	14,490.0						
Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан	1	950.0			1	950.0						
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>22,289.3</b>	<b>1</b>	<b>4,041.3</b>	<b>3</b>	<b>18,248.0</b>						

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны зөрчил	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-